



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

Нийслэл, дүүргийн оны “Тэргүүний биеийн тамирын хамтлаг” шалгаруулах тухай

Монгол Улсын Засаг захиргааны, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2006 оны 165 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэл, дүүргийн Нутгийн захиргааны байгууллагуудын дэргэдэх Биеийн тамирын хамтлагуудын үйл ажиллагааны тайлан үр дүнг үндэслэн Нийслэл, дүүргийн 2017 оны “Тэргүүний биеийн тамирын хамтлаг”-уудыг шалгаруулсугай.
2. Нийслэл, дүүргийн 2017 оны “Тэргүүний биеийн тамирын хамтлаг”-уудын шагналын төсвийг хавсралтаар баталсугай.
3. Шагналд шаардагдах 4.400.000 /дөрвөн сая дөрвөн зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний төсвөөс гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.
4. Шалгаруулалтын арга хэмжээг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын
хорооны даргын 2017 оны 11 сарын 22-ны өдрийн дугаар тушаалын хавсралт



Нийслэл, дүүргийн 2017 оны "Тэргүүний биеийн тамирын хамтлаг" шалгаруулах төсөв

№	Зардлын нэр	Шагнал /төг/	Дүн /төг/
1.	Нийслэл, дүүргийн харьяа байгууллагуудын биеийн тамирын хамтлаг	1-р байр	1000.000
		2-р байр	800.000
		3-р байр	1.800.000
2.	Цом, өргөмжлөл	600.000	600.000
3.	Анонс, урилга, бичлэг	200.000	200.000
ДҮН:		4.400.000	4.400.000

БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАСАН:

А.БОЛДМАА
О.ЭРДЭНЭЦЭЦЭГ